



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
 2025 оны 06 дуаар сарын 05-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-8
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	9-15

Өргөн барьсан төслүүдийг Байнгын хороодод хуваарилсныг мэдээлэх	8-13
1“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжлэл/	13
2.Батлагдсан хууль, тогтоолын эцсийн найруулга сонсох	13-15

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит
чуулганы 06 дугаар сарын 05-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 69 гишүүн хүрэлцэн ирж, 54.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баттулга, Г.Ганбаатар, Ц.Мөнхбат;

Чөлөөтэй: Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Амарсайхан, П.Батчимэг, Р.Сэддорж,
Д.Үүрийнтуяа;

Тасалсан: Ц.Баатархүү, Б.Батбаатар, Д.Ганбат, Л.Гантөмөр, Т.Доржханд,
Б.Жавхлан, Д.Жаргалсайхан, П.Мөнхтулга, Ц.Мөнхтуяа, Э.Одбаяр, Б.Пунсалмаа,
Ц.Туваан, Х.Тэмүүжин, А.Ундраа, Н.Учрал, Г.Уянгахишиг, Д.Цогтбаатар,
Ж.Чинбүрэн, Б.Чойжилсүрэн, Л.Энх-Амгалан, Б.Энхбаяр, Ж.Энхбаяр,
Р.Эрдэнэбүрэн;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан-04 минут, Т.Аубакир-03 минут, М.Бадамсүрэн-
13 минут, Ж.Батсуурь-02 минут, Н.Батсүмбэрэл-01 минут, Б.Батцэцэг-01
минут, Ж.Баярмаа-09 минут, Х.Болормаа-04 минут, Х.Булгантуяа-12 минут,
Ж.Галбадрах-04 минут, А.Ганбаатар-06 минут, С.Ганбаатар-08 минут,
Б.Дэлгэрсайхан-04 минут, Х.Жангабыл-02 минут, Ж.Золжаргал-01 минут,
С.Лүндэг-10 минут, Т.Мөнхсайхан-12 минут, З.Мэндсайхан-14 минут,
Б.Найдалаа-01 минут, О.Номинчимэг-01 минут, С.Одонтуяа-09 минут, Ц.Сандаг-
Очир-02 минут, О.Саранучулуун-03 минут, С.Эрдэнэбат-05 минут.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д “Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол Зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ.” гэж заасны дагуу Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл болон уг хуультай холбогдуулан боловсруулсан хуулийн төслийг Засгийн газраас 2025.05.21-ний өдөр өргөн мэдүүлснийг Хууль зүйн байнгын хороонд;

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Засгийн газраас 2025.05.27-ны өдөр өргөн мэдүүлснийг Хууль зүйн байнгын хороонд;

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Засгийн газраас 2025.05.27-ны өдөр өргөн мэдүүлснийг Хууль зүйн байнгын хороонд;

Арилжааны хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Засгийн газраас 2025.05.27-ны өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд;

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 20 гишүүнээс 2025.05.30-ны өдөр өргөн мэдүүлснийг Хууль зүйн байнгын хороонд тус тус хуваарилсныг мэдээлэв./10:04/

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан хэлэлцүүлгийн шатанд байгаа дараах хууль, тогтоолын төслүүдийг Байнгын хороо тус бүрээр танилцуулав. Үүнд:

Нэг.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд:

1.Монгол Улсын Засгийн газраас 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн “Эрчим хүч-3 төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл;

Хоёр. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд:

2.Монгол Улсын Засгийн газраас 2025.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

3.Монгол Улсын Засгийн газраас 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд;

Гурав.Нийгмийн бодлогын байнгын хороонд:

4.Монгол Улсын Засгийн газраас 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

5.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин нарын 41 гишүүн 2025.05.09-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд;

6.Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 4 гишүүн 2025.03.31-ний өдөр өргөн мэдүүлсэн Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл;

7.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

Дөрөв.Төрийн байгуулалтын байнгын хороонд:

8.Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 3 гишүүн 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

9.Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 26 гишүүн 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

10.Монгол Улсын Засгийн газраас 2025.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

11.Монгол Улсын Засгийн газраас 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

Тав.Хууль зүйн байнгын хороонд:

12.Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу нарын 19 гишүүн 2024.12.27-ны өдөр өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

13.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын 2025.04.04-ний өдөр өргөн мэдүүлсэн Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

14.Монгол Улсын Засгийн газраас 2025.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

15.Монгол Улсын Засгийн газраас 2025.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

16.Монгол Улсын Засгийн газраас 2025.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

17.Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 20 гишүүн 2025.05.30-ны өдөр өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

18.Монгол Улсын Засгийн газраас 2024.12.27-ны өдөр өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл;

19.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүн 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд;

20.Монгол Улсын Засгийн газраас 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

21.Монгол Улсын Засгийн газраас 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн Жагсаал цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

Зургаа.Эдийн засгийн байнгын хороонд:

22.Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангаас 2025.05.02-ны өдөр өргөн мэдүүлсэн Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

23.Монгол Улсын Засгийн газраас 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

24.Монгол Улсын Засгийн газраас 2025.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн Арилжааны хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

25.Монгол Улсын Засгийн газраас 2025.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд тус тус хэлэлцүүлгийн шатанд явж байгаа талаар танилцуулав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Улсын Их Хурлын 6 Байнгын хороонд хэлэлцэх эсэх шатандаа 14, анхны хэлэлцүүлгийн шатанд 11, нийт 25 хууль, тогтоолын төслүүд хэлэлцэгдэж байгааг танилцуулж, Байнгын хороодын дарга нарт хууль, тогтоолын төслүүдийг Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулган завсарлах хугацаатай уялдуулан хэлэлцүүлгүүдийн хугацааг анхаарч ажиллах чиглэл өгөв./10:07/

Нэг.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн санал хураалтаар үргэлжлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 70

Татгалзсан 20

Бүгд 90

77.8 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Батлагдсан хууль, тогтоолын эцсийн найруулга сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Бад.Баярмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан дараах хууль, тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./10:10/

2.Дагалдан гарсан “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:11/

3.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./10:11/

4.Дагалдан гарсан Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./10:11/

5.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./10:12/

6.Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./10:12/

7.Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./10:12/

8.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./10:12/

9.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./10:13/

10.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./10:13/

11.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:13/

12.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:14/

13.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:14/

14.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:14/

Уг асуудлыг 10 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 14 минут үргэлжилж, 126 гишүүнээс 95 гишүүн хүрэлцэн ирж, 75.4 хувийн ирцтэйгээр 10 цаг 14 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон “Их хуралдай” танхим 10 цаг 00 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая. 69 гишүүн ирцэд бүртгэгдэж ирц 54.8 хувьтай болсон байна.

2025 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сарын 5-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

За чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдөр 2 асуудал байгаа.

Байнгын хороодоос хуулийн төслүүдийн хэлэлцэх асуудлууд нь эцэслэн шийдэгдэхгүй бас удаж байгаа учраас чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал бас тоо их цөөрч байна. Тэгээд би бас энэ талаар танилцуулга хийе ээ гэж бодож байна.

Өнөөдөр 2 асуудлыг хэлэлцэх нь.

Нэгдүгээрт, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Хоёрдугаарт баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөхтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

Нэг.Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газраас 2025 оны 5 дугаар сарын 21-ний өдөр өргөн мэдүүлснийг Хууль зүйн байнгын хороонд.

Хоёр.Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газраас 5 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлснийг Хууль зүйн байнгын хороонд.

Гурав.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, Шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газраас 5 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлснийг Хууль зүйн байнгын хороонд.

Дөрөв.Арилжааны хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газраас 5 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд.

Тав.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан хамт өргөн боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин нарын 20 гишүүн 5 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлснийг Хууль зүйн байнгын хороонд тус тус хуваарилсан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хэлэлцүүлгийн шатанд байгаа хууль тогтоолын төслүүдийг Байнгын хороо тус бүрээр нь танилцуулъя аа.

Нийтдээ 25 орчим хуулийн төсөл болон тогтоолын төслүүд Байнгын хороод дээр одоо хэлэлцүүлгийн шатанд явж байна. Нэг ёсондоо одоо Байнгын хороодын ажил удаашралтай байна аа гэж хэлэхэд одоо болохгүй зүйлгүй болсон байна аа гэдгийг бас энэ дашрамд та бүхэнд хэлье.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд.

Засгийн газраас 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн “Эрчим хүч-3” төслийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл хэлэлцүүлгийн шатанд явж байна.

Хоёр. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд.

Засгийн газраас 1 дүгээр сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл явж байна. Одоо энэ чинь үндсэндээ 5 дахь сар дээрээ явж байна гэсэн үг. Энэ хуулийн төсөл ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа. Одоо хүртэл орж ирээгүй байна. Тэгэхээр энэ ажлын хэсэг болон Байнгын хороо уг асуудалд анхаарлаа хандуулах нь зүйтэй.

Засгийн газраас 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд тус тус анхны хэлэлцүүлгийн шатанд явж байна аа.

Нийгмийн бодлогын байнгын хороонд.

Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл байна. Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшин нарын 41 гишүүн 5 дугаар сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий

хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд тус тус хэлэлцэх эсэх шатандаа явж байна.

Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн нарын 4 гишүүн 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр өргөн мэдүүлсэн Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн 2 хуулийн төсөл, мөн Эрхтэн, эд эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд анхны хэлэлцүүлгийн шатанд явж байна аа.

Төрийн байгуулалтын байнгын хороонд.

Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин нарын 3 гишүүн 3 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд явж байна.

Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл нарын 26 гишүүн 3 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын Хяналт, шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд тус тус хэлэлцэх эсэх шатандаа явж байна.

Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр өргөн мэдүүлсэн нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд тус тус анхны хэлэлцүүлгийн шатанд явж байна.

Хууль зүйн байнгын хороонд.

Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуу нарын 19 гишүүн 12 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл байна.

Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар 2025 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр өргөн мэдүүлсэн Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд байна.

Засгийн газраас 2025 оны 5 дугаар сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Засгийн газраас 2025 оны 5 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Засгийн газраас 2025 оны 5 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх

зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин нарын 20 гишүүн 5 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд тус тус хэлэлцэх эсэх шатандаа явж байна.

Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл.

Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар нарын 9 гишүүн 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд.

Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн Жагсаал цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд тус тус анхны хэлэлцүүлгийн шатанд байна.

Эдийн засгийн байнгын хороонд.

Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан 2025 оны 5 дугаар сарын 2-ны өдөр өргөн мэдүүлсэн Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгад нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Засгийн газраас 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Засгийн газраас 2025 оны 5 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Арилжааны хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд тус тус хэлэлцэх эсэх шатандаа явж байна.

Ингээд Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд анхны хэлэлцүүлгийн шатанд явж байна аа.

Ингээд Улсын Их Хурлын 6 Байнгын хороонд хэлэлцэх эсэх шатандаа 14, анхны хэлэлцүүлгийн шатанд 11, нийт 25 хуулийн хууль, тогтоолын төслүүд хэлэлцэгдэж байна.

Тийм учраас Байнгын хороод эдгээр хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцүүлэх үйл явцыг хурдлуулах, Их Хурлын үйл ажиллагааг хэвийн явагдах нөхцөлөөр хангахад Байнгын хорооны дарга нарт анхааруулах чиглэлийг өгч байна аа.

За хэлэлцэх асуудалдаа орно оо.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Шууд санал хураалт байгаа. Гишүүдийг танхимдаа суудлаа эзлэхийг хүсье.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байна.

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна аа. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Санал хураалт Байнгын хорооны саналаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна аа. Санал хураалт.

За 70 гишүүн буюу 77.8 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийг баталлаа.

Ганбаа гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе. Улсын Их Хурлын гишүүдэд талархал дэвшүүлье ээ.

Дараагийн асуудалд оръё.

Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Д.Амарбаясгалан: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3-д Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль, тогтоолын эцсийн найруулгатай танилцаж, ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу хууль, тогтоолын эцсийн найруулгыг Байнгын хороод бэлтгэж, Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болсон байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан Засгийн газрын Өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

1.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

7.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

8.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хуулийн төсөл буцаах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Цусны донорын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг буцааж байгаа.

Хуулийн төсөл буцаах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

За ингээд Байнгын хороодод чиглэл өгсөн. Гишүүд Байнгын хорооныхоо хуралд идэвхтэй оролцож, Байнгын хороонд орж ирсэн асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх асуудал дээр бас анхааралтай хандаж ажиллахгүй бол Байнгын хорооноос одоо нэг хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудал өчигдрийн байдлаар жишээлбэл Хууль зүйн байнгын хорооноос 3 дахь удаагаа ажлын хэсэгт буцаагдаж байна. Нэг, хоёрхон заалт дээр гишүүд хоорондоо маргалдаад, бие биедээ ацаг тавиад, асуудлыг хэлэлцэхээс бас хойш нь чангааж байгаа ийм тохиолдол гарч байна. Энэ дээр одоо гишүүдийг одоо зөвшилцлийн арга замаар энэ

хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхтэй холбоотой асуудал дээр байр сууриа илэрхийлж ажиллахыг бас хүсэж байна.

Нэг хуулийн нэг заалт нэг гишүүнд таалагдаагүйгээс болоод бүхэл бүтэн одоо том хууль Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд орох боломж хангагдахгүй байна. Байнгын хорооны хурлыг бас удаа дараа үймүүлсэн гэсэн мэдээлэл бас ирж байна. Тэгэхээр ер нь энэ дээр одоо гишүүд маань анхаарлаа хандуулж ажиллахгүй бол Улсын Их Хурлын үйл ажиллагаанд одоо саатал учрах эрсдэлтэй байгаа гэдгийг бас энэ дашрамд хэлье ээ.

Ингээд өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дуусаж байна. Даргын дэргэдэх зөвлөл 11 цагаас эхэлнэ ээ.

10.14 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ
ХЯНАСАН: ГЭРЭЭТ АЖИЛТАН*

Д.ЭНЭБИШ